



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 4/588

Алтай хот

**Нийгмийн ажилтны ёс зүйн салбар
хороо байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/151 дугаар тушаалаар батлагдсан “Монголын нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм”-ийн 6.2, 6.5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар хорооны дарга: (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүдэд:

(Боловсрол, шинжлэх ухааны газрын тэгш хамран сургалт, хүүхдийн хамгаалал хариуцсан мэргэжилтэн)

(Эрүүл мэндийн газрын сургалт, сурталчилгааны асуудал хариуцсан мэргэжилтэн)

(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын халамжийн хэлтсийн дарга)

(Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн)

(Нийгмийн ажилтны холбооны аймгийн салбар зөвлөлийн тэргүүн) (тохиролцсоноор)

Нарийн бичгийн дарга: (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хүүхдийн хөгжил, хамгаалал хариуцсан ахлах мэргэжилтэн)

2.Салбар хорооны үйл ажиллагааны дүрмийг баталж, хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлж ажиллахыг салбар хорооны даргад үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/609 дүгээр захирамжийг хүчингүй болгосонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

